



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/645

Сайншанд сум

**Газар эзэмшүүлэх төсөл сонгон
шалгаруулалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”, Засгийн газрын 2025 оны 06 дугаар тогтоол, Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайншанд сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмшүүлж, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулсугай.

2. Төсөл сонгон шалгаруулах зарчмаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зохион байгуулах хугацааг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Ц.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Март)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТЖАРГАЛ

44 25 1 2062

Аймгийн Засаг даргын
2025 оны 10 дүгээр сарын 20 ны өдрийн
А/645 дугаар захирамжийн хавсралт



**ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАРЧМААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ,
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУГАЦАА**

Д/д	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Байршил	Зориулалт	Талбайн хэмжээ (га)	Хугацаа /жил/	Зохион байгуулах хугацаа
	1	2	3	4	5	6
1	4744064	6 дугаар багийн нутаг дэвсгэр	Дэд бүтцийн байгууллага	60	15	2025.11.25